



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2005 оны 3 сарын 25-аар

Дугаар 101

Улаанбаатар хот

“Усны барилга байгууламж” нийслэлийн өмчтүүлэх  
үйлдвэрийн газрын дүрмийг батлах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 78 дугаар зүйлийн 2 дугаар заалтыг 2 дахь хэсэг, Засгийн газрын 2005 оны 15 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны харьяа “Улаанбаатар-Ус” нийслэлийн өмчтүүлэх үйлдвэрийн газрыг “Усны барилга байгууламж” нийслэлийн өмчтүүлэх үйлдвэрийн газар болгон вөрчлөн зохион байгуулсантай холбогдуулан дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Батлагдсан дүрмийг мөрдэж ажиллахыг “Усны барилга байгууламж” НӨҮГ /Ё.Батболд/-т үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2002 оны 74 дүгээр захирамжийн 1 дүгээр заалтыг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД

2

Нийслэлийн Засаг дарын 2005 оны  
30 сарын 25-ны одрийш  
101 дундаж захирамжийн хавсралт

## “УСНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ” КОМПАНИЙН ДҮРЭМ

### Нэг. Ерөнхий зүйл

1.1. “Усны барилга байгууламж” Нийслэлийн Өмчийт Үйлдвэрийн газар нь /цаашид компани гэсэ/ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн харьяа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дахуу Улаанбаатар хотыг үер, хур тупадасны болон хөрсний уснаас хамгаалах барилга байгууламжийн, хотын зам талбайш хурын ус зайнлуулах ил далд шугам сүлжээний засвар арчилалт, өрөмдмөл худаг гаргах үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд эрхтэн явуулах зорилгоор байгуулагдсан компани юм. Тус компани нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар аж ахуйн тооцооны үндсэн дээр ажиллана.

1.2. Компанийн үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон Орон нутгийн Өмчийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг дарга, Хотын ерөнхий менежерийн шийлдвэрүүд болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3. Компани нь өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар аж ахуйн тооцоон дээр ажиллах ба шийслэлийн захиалгаар үйл ажиллагаа явуулж үйлчилгээнийхээ гүйцэтгэээр хотын төсвөөс санхүүжигдэж болно.

1.4. Компани нь тогтоосон журмын дагуу хийгдсэн тэмдэг албан бичгийн хэвлэмэл хуудас, банкинд харилцах данстай байна.

1.5. Компани нь Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хороо /Хар хорин захын баруул талд/ насос станцын байранд байрлана. /Утас 634373, 631290/

### Хоёр. Удирдлагын зохион байгуулалт

2.1. Компанийн захирлын Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч томилж, чолоолтө.

2.2. Компанийн захирлын эрх үүрэг, хариуцлага, цалин хэлс, урамшуулал болон бусад харилцааг Нийслэлийн өмчийн харилцааны газартай байгуулсан гэрээгээр зохицуулна.

2.3. Компани нь үйл ажиллагаагаа Улаанбаатар хотын Захирагч, түүний ажлын албанц тайлагнана.

2.4. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч компанийн дүрмийг бататж, бүтэц орон тооны хязгаарт Улаанбаатар хотын срохийн менежер бөгөөд Захирагчийн Ажлын Албаны дарга хяналт тавина.

2.5. Компанийн захидал нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хөдөлгөрийн дотоод журам, цалин, урамшиуулсын хэмжээг тогтоож мөрдүүлэх ба албан хаагчдыг томилж чөлөөлнө.

### **Гурв. Компанийн үүрэг**

3.1. Компани нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэр зам талбайл буусан хуртууласны болон хөрсний усыг зайлцуулах инженерийн шугам сүлжээ, үерийн хамгаалалтын далан сувгийн ашиглалт засвар арчилгаа, өргөлтийн насосны ажил үйлчилгээ, гүний болон бусад төрлийн худаг усны ажил үйлчилгээг явуулна.

3.2. Компани нь үерийн хамгаалалтын далан суваг, гадаргуунийн ус хүлээн авах барилга байгууламж, хотын зам талбайн ус зайлцуулах шугам сүлжээ, насос станицын топог төхөөрөмжийн засвар үйлчилгээг технологийн горимыш дагуу хийж гүйцэтгэнэ.

3.3. Компани нь далан суваг ус зайлцуулах байгууламжийн засвар арчлалтын сан байгуулж эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлүүлэх, гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татах боломж нөхцлийг бүрдүүлэх талаар нутгийн захиргааны байгууллагуудтай хамтарч ажилдана.

3.4. Компани нь ажил үйлчилгээний чиглэлийн дагуу байгууллага, иргэдээс ирсэн санал гомдолыг барагдуулах ажлыг зохион байгуулна.

3.5. Компани нь үйл ажиллагааны чиглэлийн дагуу гарсан хууль тогтоомж, Нийслэлийн удирдлагын захирамж, шийдвэрийн бисэлтийг хангуулах, гарсан зэрчил дутагдлыг арилгуулж хохирлыг барагдуулна.

3.6. Компани нь оорийн үйл ажиллагааны хүрээнд байгаль орчныг бохирдлоос сэргийлэхэд чиглэгдсэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.7. Компани нь үндсэн хөрөнгөнд хамаарах эд хөрөнгө шинээр олж авах, бусад этгээдэд эзэмшиүүлэх ашиглуулах, шилжүүлэх болон худалдах, данснаас хасахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу асуудлыг шийдвэрлэнэ.

3.8. Компанийн удирдлага компанийн үйл ажиллагаанд шалгалт хийхдээ шаардагдах бүх материалыар хангана.

3.9. Компани нь ажил үйлчилгээг өргөтгөхтэй холбогдуулан машин механизм техник тоноо төхөөрөмж, сэлбэг, материал олж авах, өөрийн ажилдаа дэвшилтэг технологийг нэвтрүүлэн ажилтана.

### **Доров. Компанийн эрх**

4.1. Компанийн өмч хөрөнгийн Монгол Улсын хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн засаг даргын шийдвэр болон энэхүү дүрэмд нийцүүлэн эзэмшиж, ашиглаж захиран зарцуулна.

4.2.Компанийн хариуцах ажил үйлчилгээний асуудлаар гадаад орын болон өөрийн улсын холбогдох эрх бүхий байгууллагын эрх олгосны дагуу гэрээ хэлцэл хийж хамтран ажиллана.

4.3.Компанийг өргөтгөх шинэ техник технологи нэвтрүүлэх, үйл ажиллагааг бодовсронгуй болгох чиглэлээр төр захирагааны байгууллагаас зохиож байгаа төсөл, хөтөлбөрт оролцох санал дүгнэлтээ тавина.

4.4.Компани нь оорийн эзэмшилд байгаа үерийн хамгаалалтын далан суваг, зам талбайн хурын ус зайлцуулах шугам сүлжээнд зөвшөөрөлгүй холболт хийн ашигласан, хог хаягдаа хийсэн байгууллага, иргэд, аж ахуйн нэгжид торгууль ногдуулан хариуцлага тооцож ажиллана.

4.5.Компанийн ажлын үр дүнгээр ажиллагдац нэмэгдол хөлс олгох, шагнаж урамшуулах, амьдрал ахуйд нь тусалж дэмжих асуудлыг дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

#### **Тав. Эд хөрөнгө , санхүүгийн бүртгэл хяналт**

5.1.Компанийн эд хөрөнгө, санхүүгийн бүртгэл тайланг Монгол Улсын нийтлан бodoх бүртгэлийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу явуулна.

5.2.Компанийн санхүүгийн жил нь тухайн оны 1 дүүсөр сарын 1-нээс эхэлж 12 дугаар сарын 31-ний өдөр дуусна. Санхүүгийн ажлын жил нь компани байгуулагдсан өдрөөс эхэлж хуанлийн жилийн 12 дугаар сарын 31-ний өдөр дуусах ба санхүүгийн сүүлчийн жил нь компанийг татан буулгасан өдрөөр дууссац тооцно.

5.3.Компани нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу орлогын болон бусад татвар хураамжийг төлнө.

5.4.Компани нь анхан шатны бүртгэлийн баталгаажигдсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар гаргаж татварын алба, Сапхүүгийн байгууллагад тушаана.

5.5.Компани нь Монгол Улсын Хууль тогтоомжийн дагуу хөрөнгийн элэгдэл хороодлын шимтгэлийг тооцно.

5.6.Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хууль тогтоомжид заасан байгууллага хэрэгжүүлнэ.

5.7.Компанийн удирдлага компанийн үйл ажиллагаанд шалгалт хийхэд шаардагдах бүх баримт материалыар хангана.

5.8.Компанийн тооцоо, тайлангийн мөнгөн дүнг төгрөгөөр илэрхийлж. Бэлэн мөнгө болон банкинд хадгалагдаж буй бусад мөнгөн хөрөнгө, түүпчлэн орлуото зарлага, төлөгдөөгүй өр зэрэг нь анх оруулсан валютын хэлбэрээр байна. Нягтлан бodoх бүртгэлийн бичилт хийх зорилгоор төгрөгт хөрвүүлэхэд Монгол банкны тухайн үеийн албан ёсны хангашаар тооцно.

5.9. Нийтийн эзэмшийн хөрөнгө болох шинээр барьж ашиглалтанд өгөх далан суваг, зам талбайн ус зайлцуулах шугам сүлжээ, гадаргуутын ус зайлцуулах барилга байгууламжийг хүлээн авч Нийслэлийн Өмчийн Харилцааны газрын шийдвэрээр дансандаа бүртгэж авна.

### **Зургаа. Хариуцлага**

6.1. Компанийн албан хаагчид нь байгууллагын дүрэм, дотоод журамд заасан үүргийг биелүүлж, байгууллагын ашиг сонирхлын төлөө шударгаар ажиллана.

6.2. Монгол Улсын хууль тогтоомж, НИТХурал, Засаг даргын шийдвэрийн биедэлтийг хэрэгжүүлэх явцад буруу шийдвэр гаргаж буслад хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон бол холбогдох хуулийн лагуу хариуцлага хүлээнэ.

6.3. Компанийн захидал нь эрх мэдлийн хэтрүүлэх буюу урвуулан ашиглах байгууллагадаа хохирол учруулсан бол уг хохирлыг өөрийн хувийн омчийн эд хөрөнгөөрөө бүрэп хариуцна.

### **Долоо. Бусад**

7.1. Энэхүү дүрмээр Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдийн нь дүрмийн салшгүй хэсэг болно.

7.2. Энэхүү дүрмэнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр зохих эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлж.